



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН
ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2021 оны 06 сарын 02 өдөр

Дугаар A/98

Улаанбаатар хот

Журам батлах тухай

ШУТИС-ийн дүрмийн 4.9.2, 4.14.7, 10.2 дахь заалтууд, ШУТИС-ийн Захирлын зөвлөлийн 2021 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

ШУТИС-ийн Эрдмийн ба хүндэт цол олгох журмыг хавсралтаар шинэчлэн баталж, 2021 оны 6 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн мөрдсүгэй.

1. ШУТИС-ийн Эрдмийн ба хүндэт цол олгох журмыг хэрэгжүүлж, хяналт тавьж ажиллахыг Эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа эрхэлсэн дэд захирал (Т.Намнан), бүрэлдэхүүн, харьяа сургууль, хүрээлэнгийн захирал нарт даалгасугай.

2. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан ШУТИС-ийн Ректорын 2016 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн А/118 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРАЛ

Б.ОЧИРБАТ



367040550



	ШУТИС-ИЙН ЭРДМИЙН БА ХҮНДЭТ ЦОЛ ОЛГОХ ЖУРАМ ШУТИС-ЭШ-ЖУ02	Эхний хэвлэлт	2003.01.27
		Өөрчилсөн огноо	2021.06.02
		Өөрчлөлтийн дугаар	2

ШУТИС-ИЙН ЭРДМИЙН БА ХҮНДЭТ ЦОЛ ОЛГОХ ЖУРАМ

Боловсруулсан:

Эрдэм шинжилгээ, инновацийн газар

Хянасан:

Эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа эрхэлсэн дэд захирал
Чанарын хяналт шинжилгээ, үнэлгээний алба
Эрдмийн ба хүндэт цолны дэд зөвлөл

Дэмжсэн:

ШУТИС-ийн ЗАХИРЛЫН ЗӨВЛӨЛ

Баталсан:

ШУТИС-ийн ЗАХИРАЛ



АГУУЛГА

АГУУЛГА.....	2
НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	3
ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ.....	3
ГУРАВ. НОРМАТИВ ЭШ ТАТАЛТ.....	3
ДӨРӨВ. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ	3
ТАВ. ЭРХ МЭДЭЛ, ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА	3
ЗУРГАА. НЭР ДЭВШИХ.....	4
ДОЛОО. ЭРДМИЙН БА ХҮНДЭТ ЦОЛ ОЛГОХ.....	5
НАЙМ. БУСАД.....	8
ХАВСРАЛТ 1. ЭРДМИЙН БА ХҮНДЭТ ЦОЛ ОЛГОХ, СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ҮЙЛ ЯВЦЫН ЗУРАГЛАЛ.....	9
ХАВСРАЛТ 2. ХОЛБОГДОХ МАЯГТ	11



НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- ШУТИС-ийн дүрэм, Эрдмийн Зөвлөлийн дүрмийг тус тус үндэслэн ШУТИС-ийн Эрдмийн болон Хүндэт цол олгох асуудлыг энэхүү журмаар зохицуулна.

ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ

- ШУТИС-ийн багш, ажилтан болоод гадаад, дотоодын нэрт эрдэмтэн, судлаач, мэргэжилтэн, олон жил идэвх зүтгэл гаргаж ажилласан хүмүүс, хамтын ажиллагаатай байгууллагын ажилтнуудад хамаарна.
- Тус журмаар эрдмийн ба хүндэт цолны сонгон шалгаруулалт, цол олгох үйл явцыг зохицуулна.

ГУРАВ. НОРМАТИВ ЭШ ТАТАЛТ

- ШУТИС-ийн дүрэм
- ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн дүрэм

ДӨРӨВ. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

- ШУТИС-ийн Хүндэт доктор цол бол ШУТИС-ийн тэргүүн дээд шагнал, Хүндэт профессор цол бол ШУТИС-ийн дээд шагнал юм.
- Профессор, дэд профессор цол нь эрдэмтэн хүнд олгодог хамгийн дээд цол ба олон жилийн судалгааны ажил ба эрдмийн ажлын амжилтын дүнд олгогдоно.

ТАВ. ЭРХ МЭДЭЛ, ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

- ШУТИС-ийн Эрдмийн зөвлөл**
 - Эрдмийн ба хүндэт цолны дэд зөвлөлийн шийдвэрийг үндэслэн, нэр дэвшигч бүрээр хэлэлцэнэ.
 - Нэр дэвшигч тус бүрээр санал хураалт явуулж, дүнг нэгтгэнэ.
 - Санал хураалтаар олонхын санал авсан нэр дэвшигчийг тодруулж, цол олгох тухай тогтоол гаргана.
- ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн дэргэдэх эрдмийн ба хүндэт цолны дэд зөвлөл**
 - Нэр дэвшигчийн материалыг ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн хурал болохоос 30 хоногийн өмнө хүлээн авна.
 - Нэр дэвшигч бүрээр хэлэлцэн, санал хураалтын үр дүнг үндэслэн шийдвэр гаргана.
 - Дэд зөвлөлөөс шалгарсан нэр дэвшигчийг ШУТИС-ийн эрдмийн зөвлөлд танилцуулна.
- Эрдэм шинжилгээ хариуцсан нэгж**
 - Бүрэлдэхүүн, харьяа сургууль, хүрээлэнгээс ирүүлсэн нэр дэвшигчийн материалыг хүлээн авч, бүртгэнэ.
 - Бүрэлдэхүүн, харьяа сургууль, хүрээлэнгээс ирүүлсэн нэр дэвшигчийн материалд хянан магадлагаяа хийнэ.



- 5.3.3 ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн дэргэдэх Эрдмийн ба хүндэт цолны дэд зөвлөлд нэр дэвшигчийн материалыг хүргүүлнэ.
 - 5.3.4 Эрдмийн ба хүндэт цолны дэд зөвлөлийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулна.
 - 5.3.5 Эрдмийн ба хүндэт цолны дипломыг батлагдсан загварын дагуу хэвлүүлнэ.
 - 5.3.6 Эрдмийн ба хүндэт цол олгох ёслолын ажиллагааг зохион байгуулна.
- 5.4 Бүрэлдэхүүн, харьяа сургууль, хүрээлэнгийн (Эрдмийн зөвлөл, ЭНБД)**
- 5.4.1 Нэр дэвшигчдийн холбогдох материалыг хүлээн авч, анхан шатны хянан магадлагаа хийнэ.
 - 5.4.2 Бүрэлдэхүүн, харьяа сургууль, хүрээлэнгийн Эрдмийн зөвлөлд нэр дэвшигчдийн материалыг хүргүүлж, хэлэлцүүлнэ.
 - 5.4.3 Нэр дэвшигчийн материалыг хэлэлцэн бүрэлдэхүүн болон харьяа сургууль, хүрээлэнгийн нэр дэвшигчийг тодорхойлно.
 - 5.4.4 Бүрэлдэхүүн, харьяа сургууль, хүрээлэнгийн Эрдмийн зөвлөлөөс гарсан шийдвэр, нэр дэвшигчдийн материалыудыг ШУТИС-ийн Эрдэм шинжилгээ хариуцсан нэгжид хүргүүлнэ.

ЗУРГАА. НЭР ДЭВШИХ

- 6.1** Эрдмийн цол олгоход дараах баримт, материалыг бүрдүүлнэ. Үүнд:
 - 6.1.1 Дэлгэрэнгүй анкет;
 - 6.1.2 Мэргэжлийн салбар, тэнхимиийн хурал, харьяа болон бүрэлдэхүүн сургууль, хүрээлэнгийн Эрдмийн зөвлөлийн хурлын шийдвэр, байгууллагын тодорхойлолт;
 - 6.1.3 Харьяа болон бүрэлдэхүүн сургууль, хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга хянаж, баталгаажуулсан бүтээлийн жагсаалт;
 - 6.1.4 Докторын зэргийн болон дэд профессор цолны дипломын хуулбар (нотариатаар баталгаажуулсан);
 - 6.1.5 Магистр, докторын төгсөлтийн ажил удирдаж, хамгаалуулсан тухай их сургуулийн захирлын тушаалын баталгаажуулсан хуулбар.
- 6.2** Хүндэт доктор, хүндэт профессор цол олгоход дараах баримт, материалыг бүрдүүлнэ. Үүнд:
 - 6.2.1 Тухайн нэр дэвшигчийн товч намтар;
 - 6.2.2 Товч танилцуулга;
 - 6.2.3 Харьяа, бүрэлдэхүүн сургууль, хүрээлэнгийн эрдмийн зөвлөлийн хурлын тэмдэглэл, шийдвэр;
 - 6.2.4 Хүндэт цол олгох үндэслэл (Олон улс ба Монгол Улсын, нийгэм, шинжлэх ухаан, технологи, инноваци, боловсролын хөгжил болон ШУТИС-т оруулсан бодит хувь нэмрийг тоо баримттай тодорхой бичих)
- 6.3** Эрдмийн ба хүндэт цол олгохтой холбоотой зардлыг нэр дэвшүүлсэн байгууллага, харьяа болон бүрэлдэхүүн сургууль, хүрээлэн хариуцна.



ДОЛОО. ЭРДМИЙН БА ХҮНДЭТ ЦОЛ ОЛГОХ

- 7.1 ШУТИС-ийн **хүндэт цол** нь хүндэт доктор, хүндэт профессор гэсэн шатлалтай байна. Үүнд:
- 7.1.1 Олон улс ба Монгол Улсын нийгэм, эдийн засаг, шинжлэх ухаан, технологи, инноваци, боловсролыг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан гадаад, дотоодын нэрт эрдэмтэн, мэргэжилтэн, олон жил идэвх зүтгэл гаргаж ажилласан хүмүүст ШУТИС-ийн бүрэлдэхүүн, харьяа сургууль, хүрээлэнгийн Эрдмийн зөвлөлийн саналыг үндэслэн ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн хурлын тогтоолоор “Хүндэт доктор”, “Хүндэт профессор” цол олгох асуудлыг шийдвэрлэнэ.
- 7.1.2 ШУТИС-ийн профессор цолтой эрдэмтэнд ШУТИС-ийн Хүндэт профессор цол олгохгүй.
- 7.2 ШУТИС-ийн эрдмийн цол нь профессор, дэд профессор гэсэн шатлалтай байна. Үүнд:
- 7.2.1 Их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад багшилсан, ажилласан хугацаа, сургалтын ажлын дадлага, туршлага, эрдэм шинжилгээний бүтээл, туурвилыг нь харгалзан журамд заасан болзлыг хангасан тохиолдолд, докторын зэрэгтэй, дэд профессор цолтой багш, ажилтанд ШУТИС-ийн профессор цол; докторын зэрэгтэй, эрдэмтэн, багш, ажилтанд ШУТИС-ийн дэд профессор цол олгоно.
- 7.2.2 Дэд профессор цол хүртсэнээс хойш 5-аас доошгүй жилийн дараа профессор цолд; докторын зэрэг хамгаалснаас хойш 3-аас доошгүй жилийн дараа дэд профессор цолд нэр дэвших эрх нээгдэнэ.
- 7.2.3 Профессор, дэд профессор цолд нэр дэвшиээд ШУТИС-ийн Эрдмийн зөвлөл, Эрдмийн ба хүндэт цолны дэд зөвлөлийн гишүүдийн олонхийн санал авч чадаагүй тохиолдолд 2 жилийн дараа дахин нэр дэвших эрх нээгдэнэ.
- 7.3 ШУТИС-ийн Хүндэт доктор, Хүндэт профессор, Профессор, Дэд профессор цолд нэр дэвшигчийн материалыг ШУТИС-ийн Эрдэм шинжилгээ хариуцсан нэгж хүлээн авч, хянан магадалж, холбогдох материалыг ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн хурал болохоос 30 хоногийн өмнө ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн дэргэдэх Эрдмийн ба хүндэт цолны дэд зөвлөлд ирүүлнэ.
- 7.4 ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн дэргэдэх Эрдмийн ба хүндэт цолны дэд зөвлөлийн хурлын шийдвэрийг ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн хуралд тус дэд зөвлөлийн нарийн бичгийн дарга танилцуулна.
- 7.5 ШУТИС-ийн Эрдмийн цолд нэр дэвшигчийн материалыг жилд нэг удаа, хүндэт цолд нэр дэвшигчийн материалыг жилд хоёр удаа хүлээн авч хэлэлцэнэ.
- 7.6 Олон улс ба Монгол Улсын нийгэм, эдийн засаг, шинжлэх ухаан, технологи, инноваци, боловсролын хөгжилд төдийгүй ШУТИС-ийн эрдэм шинжилгээ, сургалт-судалгааг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан эрдэмтэн, судлаач, хамтран ажиллагч түншүүдэд ШУТИС-ийн Хүндэт цол олгох асуудлыг ШУТИС-ийн Захирлын саналаар хүлээн авч хэлэлцэж болно.
- 7.7 ШУТИС-ийн Эрдмийн зөвлөл, ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн дэргэдэх Эрдмийн ба хүндэт цолны дэд зөвлөлийн хуралд оролцсон гишүүдийн 75-аас доошгүй хувь нь дэмжсэн тохиолдолд эрдмийн ба хүндэт цол олгох шийдвэр гаргана.
- 7.8 Профессор цолыг дараах болзол хангасан хүмүүст олгоно. Үүнд:



- 7.8.1 Их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад 15-аас доошгүй жил тасралтгүй, үр бүтээлтэй ажилласан, үүнээс ШУТИС-д 10-аас доошгүй жил ажилласан, докторын зэрэгтэй, дэд профессор цолтой байх;
- 7.8.2 Бие даан нэг сэдэвт зохиол (диссертациас гадна) 1, их сургуулийн үндсэн сурах бичиг 2-оос доошгүйг бичиж хэвлүүлсэн, гарын авлага 6-гаас доошгүйг бичиж хэвлүүлсэн, сургалтад нэвтрүүлсэн байх;
- 7.8.2.1 Тухайн сургуулийн сурган заах арга зүйн зөвлөл болон ном сурах бичгийн зөвлөлөөр хэлэлцүүлж баталгаажуулна.
- 7.8.2.2 Лаборатори, дадлагын ажлын заавар зөвлөмжийг гарын авлагад хамааруулахгүй.
- 7.8.3 Гадаад, дотоодын сэтгүүлд эрдэм шинжилгээний өгүүлэл 30-аас доошгүйг, тэдгээрээс ШУТИС-ийн нэр дээр хэвлэгдсэн 2-оос доошгүй өгүүлэл нь Web of Science, Scopus-т бүртгэлтэй сэтгүүлд хэвлэгдсэн, дэд профессор цол хүртсэнээс хойш 10-аас доошгүй өгүүлэл нийтлүүлсэн байх;
- 7.8.3.1 Олон улсын түвшинд хянан магадлагаа хийгддэг мэргэжлийн сэтгүүлд хэвлүүлсэн эрдэм шинжилгээний 2 өгүүллийг олон улсын Web of Science, Scopus-т бүртгэлтэй сэтгүүлд хэвлэгдсэн 1 өгүүлэлтэй дүйцүүлэн тооцож болно.
- 7.8.4 Олон улсын болон үндэсний хэмжээний эрдэм шинжилгээний төслийн эцсийн тайлан, ШУТИС-ийн сургалтын хөтөлбөрийг олон улсад магадлан итгэмжлүүлсэн тайлан, зохиогчийн эрх, аж үйлдвэрийн өмчийн эрхийн хамгаалалтын гэрчилгээ, боловсруулсан батлуулсан улсын стандарт бүгд 8-аас доошгүй байх;
- 7.8.4.1 Удирдсан төсөл, хөтөлбөрөөр 4-өөс доошгүй ахисан түвшний судлаачийг дэмжиж ажиллуулсан байх, зохиогчийн эрхийн тоо 4-өөс ихгүй байна.
- 7.8.5 Мэргэжлийн дагуу шавь сургуулийн үндэс суурь бэлтгэж, 2-оос доошгүй хүний эрдэм шинжилгээний ажлыг удирдаж докторын зэрэг хамгаалуулсан, 8-аас доошгүй судлаач магистрын ажил удирдаж төгсгөсөн байх;
- 7.8.5.1 Докторантын эрдэм шинжилгээний 2 ажлын зөвлөхөөр ажиллаж докторын зэрэг хамгаалуулсан бол 7.8.5 заалтын 1 докторын ажлыг удирдсантай дүйцүүлэн тооцож болно.
- 7.8.5.2 Олон улсын мэдээллийн сан Web of Science, Scopus-т бүртгэлтэй сэтгүүлд нэгдүгээр зохиогч (first author) болон холбоо барих зохиогч (corresponding author)-оор ШУТИС-ийн нэр дээр 4 бүтээл хэвлүүлсэн тохиолдолд 4 хүртэлх тооны магистрын ажил удирдсантай дүйцүүлэн тооцож болно.
- 7.8.5.3 Мэргэжлийн магистрын 2 ажил удирдсанг судлаач магистрын 1 ажил удирдсантай адилтган тооцож болно.
- 7.8.6 ШУТИС-ийн эзэмшил бүхий 4 хүртэлх тооны аж үйлдвэрийн өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулсан тохиолдолд энэхүү журмын 7.8.4 заалтыг дүйцүүлэн



тооцож болно (аж үйлдвэрийн өмч нь лицензийн гэрээгээр баталгаажсан байна).

7.9 Дэд профессор цолыг дараах болзол хангасан хүмүүст олгоно. Үүнд:

- 7.9.1 Их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад 8-аас доошгүй жил тасралтгүй, үр бүтээлтэй ажилласан, үүнээс ШУТИС-д 3-аас доошгүй жил багшилсан, докторын зэрэгтэй байх;
- 7.9.2 Их, дээд сургуульд зориулсан сурах бичиг 1, гарын авлага 3-аас доошгүйг бичиж хэвлүүлсэн, сургалтад нэвтрүүлсэн байх
 - 7.9.2.1 Тухайн сургуулийн сурган заах арга зүйн зөвлөл болон ном сурах бичгийн зөвлөлөөр хэлэлцүүлж баталгаажуулсан байна.
 - 7.9.2.2 Лаборатори, дадлагын ажлын заавар зөвлөмжийг гарын авлагад хамааруулахгүй.
- 7.9.3 Гадаад, дотоодын сэтгүүлд эрдэм шинжилгээний өгүүлэл 20-иос доошгүйтгээс ШУТИС-ийн нэр дээр хэвлэгдсэн 1-ээс доошгүй өгүүлэл нь Web of Science, Scopus-т бүртгэлтэй сэтгүүлд хэвлэгдсэн, эрдмийн зэрэг хамгаалснаас хойш 3-аас доошгүй өгүүлэл нийтлүүлсэн байх;
 - 7.9.3.1 Олон улсын түвшинд хянан магадлагаа хийгддэг мэргэжлийн сэтгүүлд хэвлүүлсэн 2 эрдэм шинжилгээний өгүүллийг олон улсын Web of Science, Scopus-т бүртгэлтэй сэтгүүлд хэвлэгдсэн 1 өгүүлэлтэй дүйцүүлэн тооцож болно.
- 7.9.4 Олон улсын болон үндэсний хэмжээний эрдэм шинжилгээний төслийн эцсийн тайлан, ШУТИС-ийн сургалтын хөтөлбөрийг олон улсад магадлан итгэмжлүүлсэн тайлан, зохиогчийн эрх, аж үйлдвэрийн өмчийн эрхийн хамгаалалтын гэрчилгээ, боловсруулан батлуулсан улсын стандарт 5-аас доошгүй байх (зохиогчийн эрхийн тоо 3-аас ихгүй байна);
- 7.9.5 Судалгааны ажил бичсэн 3-аас доошгүй магистрын ажлыг удирдаж хамгаалуулсан байх;
 - 7.9.5.1 Мэргэжлийн магистрын 2 ажил удирдсанг судлаач магистрын 1 ажил удирдсантай адилтган тооцно.
 - 7.9.5.2 Олон улсын мэдээллийн сан Web of Science, Scopus-т бүртгэлтэй сэтгүүлд нэгдүгээр зохиогч (first author) болон холбоо барих зохиогч (corresponding author)-оор ШУТИС-ийн нэр дээр 3 бүтээлийг хэвлүүлсэн тохиолдолд энэхүү журмын 7.9.5 заалтыг дүйцүүлэн тооцож болно.
- 7.9.6 ШУТИС-ийн эзэмшил бүхий 2 хүртэлх тооны аж үйлдвэрийн өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулсан тохиолдолд энэхүү журмын 7.9.4 заалтыг дүйцүүлэн тооцож болно (аж үйлдвэрийн өмч нь лицензийн гэрээгээр баталгаажсан байна).

ШУТИС-ийн захирлын 2006 оны 06.-р сарын
02-ний өдрийн 1998-дугаар тушаалын хавсралт



НАЙМ. БУСАД

- 8.1. Хүндэт цол олгох ёслолыг тусгайлсан дэгийн дагуу хийх ба нэр дэвшигчийн намтар, урилга, хөтөлбөрийг хэвлэж тараасан байна.
- 8.2. Эрдмийн ба хүндэт цол олгохтой холбоотой зардлыг нэр дэвшүүлсэн байгууллага, харьяа болон бүрэлдэхүүн сургууль, хүрээлэн хариуцна.
- 8.3. ШУТИС-иас жилд 3-аас илүүгүй Хүндэт доктор, 10 хүртэл хүмүүст Хүндэт профессор цол тус тус олгож болно. Их сургуулийн төсөвт жил бүр шаардагдах зардлыг тусгана.
- 8.4. Эрдмийн ба хүндэт цол олгох тухай Эрдмийн зөвлөлийн хурлын тогтоолыг үндэслэн ШУТИС-ийн Захирлын тушаалаар Эрдмийн ба хүндэт цол олгоно.
- 8.5. Эрдмийн ба хүндэт цолны дипломыг батлагдсан загварын дагуу хэвлүүлж, ШУТИС-ийн Захирал гарын үсэг зурж баталгаажуулна.



ХАВСРАЛТ 1. ЭРДМИЙН БА ХҮНДЭТ ЦӨЛ ОЛГОХ, СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ҮЙЛ ЯВЦЫН ЗУРАГЛАЛ

ОРОЛЦООНЫ ТАЙЛБАР: [Responsibility] - Хариуцан хийж, гүйцэтгэх; [Accountability] - Тухайн алхамд хариуцлага хүлээх, батлах; [Consulted] - Тухайн алхмыг гүйцэтгэхдээ зөвлөлдөх, хамтрах оролцох; [Informed] – Алхмын гаралтыг мэдээлэх

№	Оролт	Үйл явц	Гаралт	Оролцоо (RACI)					
				НД	ЭНБД	БС-ЭЗ	ЭШХН	Ш-ЭДЗ	Ш-ЭЗ
1	ЭШХН-ийн үйл ажиллагааны төлөвлөгөө	Эрдмийн ба хүндэт цолны шалгаруулалтыг зарлах	Зарлал	I	I		R		
2	Тус журам, түүний хавсралтууд	Материал бүрдүүлэх	Нэр дэвшигчийн анкет, бүтээлийн жагсаалт, бусад нотолгоо	R	C				
3	Нэр дэвшигчийн анкет, бүтээлийн жагсаалт, бусад нотолгоо	Нэр дэвшигчийн материал хүлээн авах	Нэр дэвшигчийн материал	C	R				
4	Нэр дэвшигчийн материал	Анхан шатны магадлагаа хийх ↓ Болзول хангасан эсэх	Анхан шатны болзол хангасан нэр дэвшигч		R		C		
5	Болзол хангасан нэр дэвшигч	БС-ийн эцсийн шалгаруулалт хийх ↓ Шалгарсан эсэх	БС, хүрээлэнгээс нэр дэвшигч БС, хүрээлэнгийн ЭЗ-ийн хурлын тэмдэглэл	I	R	A			
6	БС-иас нэр дэвшигчийн материал БС, хүрэлэнгийн ЭЗ-ийн хурлын тэмдэглэл	Шалгарсан нэр дэвшигчийн материалыг ЭШИГ-т хүргүүлэх/ хүлээн авах	Нэр дэвшигчийн бүртгэл, материал		R		A		
7	Нэр дэвшигчийн бүртгэл	Хоёрдахь шатны магадлагаа хийх ↓ Болзол хангасан эсэх	Хоёрдахь шатны болзол хангасан нэр дэвшигч				R		



8	Хоёрдахь шатны болзол хангасан нэр дэвшигч	З дахь шатны шалгаруулалтыг зохион байгуулах ↓ Болзол хангасан эсэх	Шалгарсан нэр дэвшигчийг тодорхойлсон шийдвэр	C		R	A	
9	Шалгарсан нэр дэвшигчийг тодорхойлсон шийдвэр	Эцсийн шатны шалгаруулалт хийх	ШУТИС-ийн эрдмийн зөвлөлийн тогтоол	I		C	R	A
10	ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн тогтоол	ШУТИС-ийн захирлын тушаал гаргуулах	ШУТИС-ийн захирлын тушаал	I	I	R/A		
11	ШУТИС-ийн захирлын тушаал	Цол олгох үйл ажиллагааг зохион байгуулах	ШУТИС-ийн эрдмийн ба хүндэт цолны бүртгэл	C		R/A		

*НД- Нэр дэвшигч

*ЭНБД- Эрдэмтэн нарийн бичгийн дарга

*БС-ЭЗ – Бүрэлдэхүүн сургууль, хүрээлэнгийн эрдмийн зөвлөл

*ЭШХН- Эрдэм шинжилгээ хариуцсан нэгж

*Ш-ЭДЗ – ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн дэргэдэх Эрдмийн ба хүндэт цолны дэд зөвлөл

*Ш-ЭЗ - ШУТИС-ийн Эрдмийн зөвлөл

ШУТИС-ийн захирлын 14 оны 06.-р сарын
02.-ний өдрийн 98-дугаар тушаалын хавсралт

ХАВСРАЛТ 2, ХОЛБОГДОХ МАЯГТ



№	Маягтын нэр	Маягтын дугаар	Хадгалах эзэн/байршил
Эрдмийн цолд нэр дэвшигч			
1	Нэр дэвшигчийн дэлгэрэнгүй анкет	Төрийн албан хаагчийн анкет	ТАЗөвлөл
2	Профессор цолны болзол хангасан байдлын мэдээлэл	М-ЭШ003	ЭНБД
3	Дэд профессор цолны болзол хангасан байдлын мэдээлэл	М-ЭШ004	ЭНБД
Хүндэт цолд нэр дэвшигч			
4	Нэр дэвшигчийн товч танилцуулга	М-ЭШ005	ЭНБД



Маягт: М-ЭШ003

ПРОФЕССОР ЦОЛНЫ БОЛЗОЛ ХАНГАСАН БАЙДЛЫН МЭДЭЭЛЭЛ

Овог, нэр:

д/д	Тавигдах шаардлага	Хангасан байдал
1	Бүрэлдэхүүн сургууль, хүрээлэнгийн Эрдмийн зөвлөлийн хурлын шийдвэр /он сар, өдөр, тогтоолын №/	
2	Докторын зэрэг хамгаалсан огноо	
3	Дэд профессор цол хүртсэн огноо	
4	7.8.1. Их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад 15 -аас доошгүй жил тасралтгүй, үр бүтээлтэй ажилласан, үүнээс ШУТИС-д 10 -аас доошгүй жил ажилласан, докторын зэрэгтэй, дэд профессор цолтой байна.	
5	7.8.2. Бие даан нэг сэдэвт зохиол (диссертациас гадна) 1, их сургуулийн үндсэн сурах бичиг 2 -оос доошгүйг бичиж хэвлүүлсэн, гарын авлага 6 -гаас доошгүйг бичиж хэвлүүлсэн, сургалтад нэвтрүүлсэн байна. 7.8.2.1 Тухайн сургуулийн сурган заах арга зүйн зөвлөл болон ном сурах бичгийн зөвлөлөөр хэлэлцүүлж баталгаажуулна. 7.8.2.2 Лаборатори, дадлагын ажлын заавар зөвлөмжийг гарын авлагад хамааруулахгүй.	
6	7.8.3. Гадаад, дотоодын сэтгүүлд эрдэм шинжилгээний өгүүлэл 30 -аас доошгүйг, тэдгээрээс ШУТИС-ийн нэр дээр хэвлэгдсэн 2 -оос доошгүй өгүүлэл нь Web of Science, Scopus-т бүртгэлтэй сэтгүүлд хэвлэгдсэн, дэд профессор цол хүртсэнээс хойш 10 -аас доошгүй өгүүлэл нийтлүүлсэн байна. 7.8.3.1. Олон улсын түвшинд хянан магадлагаа хийгддэг мэргэжлийн сэтгүүлд хэвлүүлсэн эрдэм шинжилгээний 2 өгүүллийг олон улсын Web of Science, Scopus-т бүртгэлтэй сэтгүүлд хэвлэгдсэн 1 өгүүлэлтэй дүйцүүлэн тооцож болно.	
7	7.8.4. Олон улсын болон үндэсний хэмжээний эрдэм шинжилгээний төслийн эцсийн тайлан, ШУТИС-ийн сургалтын хөтөлбөрийг олон улсад магадлан итгэмжлүүлсэн тайлан, зохиогчийн эрх, аж үйлдвэрийн өмчийн эрхийн хамгаалалтын гэрчилгээ, боловсруулан батлуулсан улсын стандарт бүгд 8 -аас доошгүй байна. 7.8.4.1. Удирдсан төсөл, хөтөлбөрөөр 4 -өөс доошгүй ахисан түвшний судлаачийг дэмжиж ажиллуулсан байх, зохиогчийн эрхийн тоо 4 -өөс ихгүй байна.	
8	7.8.5. Мэргэжлийн дагуу шавь сургуулийн үндэс суурь бэлтгэж, 2 -оос доошгүй хүний эрдэм шинжилгээний ажлыг удирдаж докторын зэрэг хамгаалуулсан, 8 -аас доошгүй судлаач магистрын ажил удирдаж төгсгөсөн байна. 7.8.5.1. Докторантын эрдэм шинжилгээний 2 ажлын зөвлөхөөр ажиллаж докторын зэрэг хамгаалуулсан бол 7.8.5 заалтын 1 докторын ажлыг удирдсантай дүйцүүлэн тооцож болно. 7.8.5.2. Олон улсын мэдээллийн сан Web of Science, Scopus-т бүртгэлтэй сэтгүүлд нэгдүгээр зохиогч (first author) болон холбоо барих зохиогч (corresponding author)-оор ШУТИС-ийн нэр дээр 4 бүтээл хэвлүүлсэн тохиолдолд 4 хүртэлх тооны магистрын ажил удирдсантай дүйцүүлэн тооцож болно. 7.8.5.3. Мэргэжлийн магистрын 2 ажил удирдсанг судлаач магистрын 1 ажил удирдсантай адилтган тооцож болно.	
9	7.8.6. ШУТИС-ийн эзэмшил бүхий 4 хүртэлх тооны аж үйлдвэрийн өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулсан тохиолдолд энэхүү журмын 7.8.4 заалтыг дүйцүүлэн тооцож болно (аж үйлдвэрийн өмч нь лицензийн гэрээгээр баталгаажсан байна).	



Маягт: М-ЭШ004

ДЭД ПРОФЕССОР ЦОЛНЫ БОЛЗОЛ ХАНГАСАН БАЙДЛЫН МЭДЭЭЛЭЛ

Овог, нэр:

д/д	Тавигдах шаардлага	Хангасан байдал
1	Бүрэлдэхүүн сургууль, хүрээлэнгийн Эрдмийн зөвлөлийн хурлын шийдвэр /он сар, өдөр, тогтоолын №/	
2	Докторын зэрэг хамгаалсан огноо	
3	7.9.1 Их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад 8-аас доошгүй жил тасралтгүй, үр бүтээлтэй ажилласан, үүнээс ШУТИС-д 3-аас доошгүй жил багшилсан, докторын зэрэгтэй байна.	
4	7.9.2 Их, дээд сургуульд зориулсан сурах бичиг 1, гарын авлага 3-аас доошгүйг бичиж хэвлүүлсэн, сургалтад нэвтрүүлсэн байх 7.9.2.1 Тухайн сургуулийн сурган заах арга зүйн зөвлөл болон ном сурах бичгийн зөвлөлөөр хэлэлцүүлж баталгаажуулсан байна. 7.9.2.2 Лаборатори, дадлагын ажлын заавар зөвлөмжийг гарын авлагад хамааруулахгүй.	
5	7.9.3 Гадаад, дотоодын сэтгүүлд эрдэм шинжилгээний өгүүлэл 20-иос доошгүйг, тэдгээрээс ШУТИС-ийн нэр дээр хэвлэгдсэн 1-ээс доошгүй өгүүлэл нь Web of Science, Scopus-т бүртгэлтэй сэтгүүлд хэвлэгдсэн, эрдмийн зэрэг хамгаалснаас хойш 3-аас доошгүй бүтээл нийтлүүлсэн байх; 7.9.3.1 Олон улсын түвшинд хянан магадлагaa хийгддэг мэргэжлийн сэтгүүлд хэвлүүлсэн 2 эрдэм шинжилгээний өгүүллийг олон улсын Web of Science, Scopus-т бүртгэлтэй сэтгүүлд хэвлэгдсэн 1 өгүүлэлтэй дүйцүүлэн тооцож болно.	
6	7.9.4 Олон улсын болон үндэсний хэмжээний эрдэм шинжилгээний төслийн эцсийн тайлан, ШУТИС-ийн сургалтын хөтөлбөрийг олон улсад магадлан итгэмжлүүлсэн тайлан, зохиогчийн эрх, аж үйлдвэрийн өмчийн эрхийн хамгаалалтын гэрчилгээ, боловсруулан батлуулсан улсын стандарт бүгд 5-аас доошгүй байх (зохиогчийн эрхийн тоо 3-аас ихгүй байна);	
7	7.9.5 Судалгааны ажил бичсэн 3-аас доошгүй магистрын ажлыг удирдаж хамгаалуулсан байна. 7.9.5.1 Мэргэжлийн магистрын 2 ажил удирдсанг судлаач магистрын 1 ажил удирдсантай адилтган тооцно. 7.9.5.2 Олон улсын мэдээллийн сан Web of Science, Scopus-т бүртгэлтэй сэтгүүлд нэгдүгээр зохиогч (first author) болон холбоо барих зохиогч (corresponding author)-оор ШУТИС-ийн нэр дээр 3 бүтээлийг хэвлүүлсэн тохиолдолд энэхүү журмын 7.9.5 заалтыг дүйцүүлэн тооцож болно.	
8	7.9.6 ШУТИС-ийн эзэмшил бүхий 2 хүртэлх тооны аж үйлдвэрийн өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулсан тохиолдолд энэхүү журмын 7.9.4 заалтыг дүйцүүлэн тооцож болно (аж үйлдвэрийн өмч нь лицензийн гэрээгээр баталгаажсан байна).	



Маягт: М-ЭШ005

ХҮНДЭТ ЦОЛД НЭР ДЭВШИГЧИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

д/д	Үзүүлэлт		Нэр дэвшигчийн мэдээлэл
1	Овог, нэр		
2	Төрсөн огноо, Нас		
3	Иргэншил		
4	Албан тушаал		
5	Эрдмийн цол зэрэг		
6	ШУТИС-ийн профессор цол авсан эсэх		
7	Хүндэт цолд нэр дэвшүүлсэн сургууль, хүрээлэн		
8	a) ШУТИС-ийн багш бол тус сургуульд ажилласан жил, b) гадны байгууллагын эрдэмтэн, судлаач, бизнесмен бол хамтран ажилласан хугацаа (Эхэлсэн: он/сар/өдөр)		
9	Ажиллаж байгаа болон хамтран ажиллаж буй шинжлэх ухааны чиглэл		
10	Сургалтын чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажил (Тайлбар, тоон үзүүлэлт)	Бакалавр	
		Магистр	
		Доктор	
		Мэргэшүүлэх сургалт	
11	Судалгааны чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажил (Тайлбар, тоон үзүүлэлт)	Хамтарсан судалгаа, төсөл хэрэгжүүлэх	
		ШУ-ны ололтыг нутагшуулахад чиглэсэн инновацийн үйл ажиллагаа	
		Судалгааны материаллаг баазыг бэхжүүлэх, инновацийн дэд бүтцийг бүрдүүлэх	
12	Багшлах хүний нөөцийг хөгжүүлэх (Тайлбар, тоон үзүүлэлт)	Докторын дараах сургалт	
		Олон улсын их дээд сургуулиудад багш, судлаачдыг сургалт, судалгаанд тогтмол хамруулсан байдал	
13	Их сургуулийн хөгжлийн бодлого, стратегийн зорилт, зорилгыг хэрэгжүүлэх үйлсэд бодитой хувь нэмэр оруулсан		
14	Оюуны хөрөнгө оруулалт		
15	Материаллаг хөрөнгө оруулалт		